

Хүний Эрхийн Үндэсний Комисс
Засгийн газрын 11-р, 5-р давхар
Эрх Чөлөөний талбай, Улаанбаатар 38
Утас: 262971
Факс: 262786
Э-шуудан: info@mn-nhrc.org

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



“Монгол Улсын Үндэсний
хууль тогтоомж олон улсын
гэрээ конвенцид нийцэж
буйд шинжээчийн үнэлгээ
өгөх” ТӨСӨЛ

ОИН.МН
СУДАЛГААНЫ САН

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“Монгол Улсын Үндэсний хууль тогтоомж олон улсын гэрээ конвенцид нийцэж буйд шинжээчийн үнэлгээ гаргах” төсөл

ОРШИЛ

НҮБ-аас 2000 онд баталсан Мянганы хөгжлийн зорилтуудын хүрээнд энэхүү төслийг хэрэгжүүлж байгаа нь чухал ач холбогдолтой юм. Төслийг хэрэгжүүлэх болсон хэрэгцээ шаардлага нь дараах зүйлүүдтэй шууд холбоотой.

1. 2000 оны намар дэлхийн 189 орны төрийн тэргүүн болон ерөнхий сайд, гадаад хэргийн сайд нар оролцсон НҮБ-ын Мянганы дээд хэмжээний тусгай чуулган хийж, хүн төрөлхтний өмнө тулгарч байгаа олон чухал асуудлыг шинэ мянганд яаж шийдвэрлэх талаар ярилцсан. Ингээд юуны өмнө ядуурал, өлсгөлөнг бууруулахаар тохиролцож “Мянганы тунхаглал” гэдэг түүхэн баримт бичгийг баталж, түүндээ мянганы хөгжлийн зорилтуудыг тусгаж, улс орон бүр өөрийн хөгжлийн нөхцөл байдалд нийцүүлэн уг зорилтуудыг хэрэгжүүлэх үүргийг хүлээсэн.
2. Монгол Улсын Их Хурлын 2008 оны 1 дүгээр сарын 31-ны 13 дугаар тогтоолоор “Мянганы хөгжлийн зорилтуудын үзүүлэлт, арга зүйг боловсронгуй болгох, хэрэгжилтийг үзүүлэлт бүрээр дүгнэх, хяналт тавих, төрөлжсөн болон тусгайлсан санг улсын хэмжээнд, аймаг, нийслэлийн түвшинд холбогдох мэдээллээр бүрдүүлж ажиллахыг Хүний эрхийн Үндэсний Комисс болон бусад байгууллагуудад үүрэг болгосон.

“Монгол Улсын Үндэсний хууль тогтоомж олон улсын гэрээ конвенцид нийцэж буйд шинжээчийн үнэлгээ гаргах” төсөл нь Мянганы хөгжлийн зорилтуудын 9 дэх зорилгын хүрээнд Монгол Улсын хууль тогтоомж олон улсын гэрээ конвенцид хэрхэн нийцэж буйг үнэлэх үнэлгээний асуултууд боловсруулах, эдгээр асуултыг экспертээр үнэлүүлэх, үнэлгээг тооцоолох арга зүйг боловсруулах гэсэн үндсэн зорилтуудтай байсан.

Манай улс 1921 оноос өнөөг хүртэл 3000 орчим хоёр талт олон улсын гэрээ байгуулж, 180-аад олон талт гэрээнд нэгдэн ороод байна.¹ Монгол Улсын олон улсын гэрээ нь Үндсэн хуулийн дагуу дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилдэг. Түүнчлэн дотоодын хууль тогтоомж нь тухайн улсын нэгдэн орсон

¹ Төрийн мэдээллийн тусгай дугаар, УБ 2004 он, 1 дахь тал

олон улсын гэрээ, конвенцийн үзэл санаанд нийцэж тэдгээрийн хамгийн наад захын стандарт шаардлагыг хангаж байх ёстой.

Мянганы хөгжлийн Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх 9 дэх зорилго, Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүндэтгэж, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангаж, олон нийтэд мэдээллийг чөлөөтэй олж авах боломж олгох 20 дахь зорилтын хүрээнд Монгол Улсын дотоодын хууль олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцид нийцэж буй талаархи шинжээчдийн үнэлгээг хувиар тооцон гаргаж байна. Шинжээчдийн үнэлгээ өгөх асуулгыг боловсруулахад зөвхөн энэ салбарын судлаачид судалгаа хийх бус бусад судлаачид, мэргэжилтэн, олон нийтийн дунд хэлэлцүүлэг хийн тэдний санал зөвлөмжийг харгалзан үзсэн нь асуулга үр дүнтэй болж, үнэлгээ илүү бодитой болоход нөлөөлсөн байна.

Төслийн хүрээнд хийгдсэн ажлыг үйл ажиллагаа тус бүрээр нь дэлгэрэнгүй танилцуулъя.


Нэг. БЭЛТГЭЛ АЖИЛ

Төслийн захиалагч байгууллагаар НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Мянганы хөгжлийн зорилт 9-д дэмжлэг үзүүлэх төсөл, хүлээн авагч байгууллагаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, гүйцэтгэгч байгууллагаар Хууль зүйн Үндэсний төв тус тус ажилласан.

Бэлтгэл ажлын хүрээнд төлөвлөгөө боловсруулсан батлуулах, үнэлгээний асуултууд боловсруулах шинжээчдийг сонгох, шаардлагатай мэдээллийн нэр төрлийг тодорхойлох, үнэлгээ хийх шинжээчдийг тодорхой шалгуурын дагуу сонгох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Үнэлгээний асуултууд боловсруулах шинжээчдийг Хууль зүйн Үндэсний Төв болон Хүний эрхийн Үндэсний Комиссоос сонгон ажиллуулсан юм. Ингэхдээ тэдний ажлын туршлага, мэдлэг болон хариуцан ажиллаж буй эрхийн чиглэл, өмнө нь хийж байсан судалгааны ажил зэргийг шалгуур болгон сонгосон юм.

1. П.Баяр – ХЗҮТ-ын эрдэм шинжилгээний ажилтан
2. Н.Мөнхтуяа – ХЗҮТ-ын эрдэм шинжилгээний ажилтан
3. Г.Оюунболд – ХЗҮТ-ын эрдэм шинжилгээний ажилтан
4. М.Мөнхбат – ХЗҮТ-ын эрдэм шинжилгээний ажилтан
5. Б.Долгион – ХЭҮК-ын референт нар ажилласан.



.....

Шинжээчид Монгол улсын нэгдэн орсон хүний эрхийн гэрээ, конвенцуудаас сонгон авахдаа удирдамжинд заасны дагуу хүний халдашгүй эрхтэй шууд холбоотой болон суурь конвенц гэсэн шалгууруудыг үндэслэн сонгосон.

1. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт

/НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А(XXI) тоот тогтоолоор баталж 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1968.01.05-нд гарын үсэг зурж, 1974.11.18-нд соёрхон батласан/

2. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт

/НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1996 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200А(XXI) дугаар тогтоолоор баталж 1976 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1968.01.05-нд гарын үсэг зурж, 1974.11.18-нд соёрхон батласан/

3. Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц

/НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 34/180 тоот тогтоолоор 1979 оны 12 дугаар сарын 18-ны өдөр баталж 1981 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1980.07.10-нд гарын үсэг зурж, 1981.05.14-нд соёрхон батласан/

4. Хүүхдийн эрхийн тухай конвенц

/НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр баталж, 1990 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1990.01.26-нд гарын үсэг зурж, 1990.07.05-нд соёрхон батласан/

5. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц

/НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, 1987 оны 6 дугаар сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 2000.11.02-нд нэгдэж орсон/

6. Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц

/НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2106 (XX) тоот тогтоолоор 1965 оны 12 дугаар сарын 21-ний өдөр баталж, 1969 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр

⋮

Хоёр. АРГА ЗҮЙ

Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн холбогдолтой конвенцийн шууд үүрэг болгосон заалт, Монгол Улсын хуулийн тухайн конвенцийн заалттай шууд холбогдох заалтыг түүвэрлэн харьцуулалт хийж доорх байдлаар 1,2,3,4,5 гэсэн үнэлгээний аль нэгийг өгч нийлбэрийг нь бодох замаар ерөнхий үнэлгээ гаргана.

Хуулийн заалт	1.	2.	
Конвенцийн заалт			
1.	1-5 тоон үнэлгээ	1-5 тоон үнэлгээ	
2.	1-5 тоон үнэлгээ	1-5 тоон үнэлгээ	

Шинжээч нь судалгааны асуулгыг нөхөхдөө тухайн хуулийн заалт нь харгалзах халдашгүй эрхтэй холбоотой конвенцийн заалтын агуулгад хир зэрэг ойролцоо байгаагаар нь шалгуур болгон 1-5 хүртэлх (1,2,3,4,5 гэсэн үнэлгээний аль нэгээр) тоон үнэлгээгээр дараах байдлаар үнэлгээ өгнө.

- 1 оноо - Хангалтгүй
- 2 оноо - Хангалтгүйгээс арай дээр
- 3 оноо - Дунд зэрэг
- 4 оноо - Дундаас дээд зэрэг, гэхдээ боловсронгуй болгох шаардлагатай
- 5 оноо - Хангалттай

2. Шинжээчийн өгсөн үнэлгээг тухайн конвенц тус бүр дээр тооцон гаргахдаа доорх томъёоллоор бодож гаргана.

$$K = \frac{Y_1 + Y_2 + Y_3 + Y_4 + \dots + Y_6 + \dots}{Y_{NT}}$$

K – Үндэсний хууль нь тухайн нэг конвенцид нийцэж буй байдлын үнэлгээ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Y1 – Хууль болон конвенцийн харгалзах заалтад өгсөн үнэлгээ /нэг нүдэнд өгөх тоон үнэлгээ/

Yнт- Үнэлгээ өгсөн нийт нүдний тоо

Эцсийн үнэлгээ буюу Монгол Улсын үндэсний хууль Хүний эрхийн конвенцтой нийцэж буй байдлын үнэлгээг тооцож гаргахдаа доорх томъёоллыг хэрэглэнэ.

$$Y = \frac{K1+K2+K3+K4+K5+K6}{Kтн}$$

Y= Монгол Улсын үндэсний хууль Монгол улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн конвенцтой нийцэж буй байдлын үнэлгээ

K1-Конвенц тус бүрт өгсөн үнэлгээ /6 конвенц тус бүрт өгсөн үнэлгээ/

Kтн - Конвенцийн тооны нийлбэр

Гурав. ШҮҮМЖ АВАХ АЖИЛ

Монгол Улсын хууль тогтоомж нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээ конвенцид нийцэж буйд үнэлгээ өгөх асуулгад судлаачдын саналыг авах зорилгоор 2008 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр ХЭҮК-ын гишүүн, докторант П.Оюунчимэг, ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Т.Жаргалсайхан нараас үнэлгээний асуулгын талаарх шүүмжийг авсан нь тус асуулгыг боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

ХЭҮК-ын гишүүн, докторант П.Оюунчимэг, ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Т.Жаргалсайхан нарын өгсөн шүүмжийн дагуу зарим өөрчлөлтийг үнэлгээний асуулгад оруулсан.

Дөрөв. ҮР ДҮН

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн мянганы хөгжлийн зорилт 9-д дэмжлэг үзүүлэх төсөлтэй хамтран хэрэгжүүлсэн энэхүү төсөл нь Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтууд, тэр дундаа Монгол Улс анх удаа дэвшүүлэн тавьсан Мянганы хөгжлийн зорилт 9 биелэгдэхэд түлхэц үзүүлэх ажил болсон юм.

Монгол Улсын Үндэсний хууль тогтоомж нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээ конвенцид нийцэж буй талаархи анхны суурь тоонууд гарснаар бид одоогийн байгаа түвшнээ тодорхойлсноос гадна 2015 гэхэд хүрэх түвшинг тодорхойлох ач холбогдолтой болсон юм.




Төсөл хэрэгжсэнээр дараах үр дүнд хүрлээ.

1. Экспертүүд болон шинжээчдийг сонгох шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулсан
2. Үнэлгээ авах асуулгыг боловсруулан гаргасан
3. Асуулгын дүнг нэгтгэх бодох, арга зүйг боловсруулсан
4. Монгол улсын үндэсний хууль тогтоомж олон улсын гэрээ конвенцид нийцэж буй талаарх анхны суурь тоонууд гарсан.

Тав. ДҮГНЭЛТ

Монгол Улсын Олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцийн заалтад Монгол Улсын хууль хэрхэн нийцэж буй, цаашид хэрхэн боловсронгуй болгох тухай дараах дүгнэлтийг хийж байна.

- Хуулийг боловсруулах, батлах арга ажиллагаанд хуулийн төслийн агуулга, нэр томъёог олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх явдал дутмаг, судалгаа шинжилгээний байгууллага, мэргэжилтнүүдийг татан оролцуулах, санал дүгнэлтийг нь тусгах явдал хангалтгүй байна.
- Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын олон улсын гэрээнд заасан агуулга, үзэл санааг тусгасан байдаг боловч салбар хуулиуд болох эрүүгийн хууль, эрүүгийн байцаан шийтгэх хууль бусад хуульд хангалттай тусгаагүйгээс тухайн конвенцийн заалтын хэрэгжилт хангалтгүй байна.
- Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтийг НҮБ-ын хороод, ОУХБ-ын Шинжээчдийн хороонд тайлагнах үүргээ хангалтгүй биелүүлж байна.
- Мөн НҮБ-ын хороодоос Засгийн газрын илтгэлд ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хойрго хандах, хэрэгжүүлэхгүй байх зэрэг алдаа дутагдал оршиж байна.
- Олон улсын гэрээ конвенцийн албан ёсны орчуулга, түүнийг хэвлэн нийтлэх үйл ажиллагаа хангалтгүй байгаа нь шүүх, хуулийн байгууллагад ОУ-ын гэрээг хэрэглэхэд хүндрэл учруулж байна.
- Монгол Улсын олон улсын гэрээг олон нийтэд сурталчлан таниулах, энэ талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа хангалтгүй байна.
- Олон улсын гэрээ конвенцийн хэрэгжилтийг хариуцах байгууллагууд МУ-ын хууль тогтоомж, ОУ-ын гэрээ конвенцид нийцэж буй талаарх нэгдсэн судалгаа, мэдээллийн сан байхгүй байна.



Иймд дээрх байдлыг засахын тулд доорх арга хэмжээг авах шаардлагатай байна.

- Монгол Улсын хуулийг, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэхдээ судалгаа шинжилгээний байгууллага, мэргэжилтнүүдийг татан оролцуулах, санал дүгнэлтийг нь тусгах;
- Хүүхдийн эрхийн тухай конвенц, тэдгээрийн нэмэлт протоколуудаас бусад олон улсын гэрээний хэрэгжилтийг тайлагнах хугацаа 1-6 жилээр хэтэрч байгаа боловч Засгийн газраас тайланг НҮБ-ын холбогдох хороодод хүргүүлэх шуурхай арга хэмжээ авахгүй байгааг анхаарах шаардлагатай байна. Иймд олон улсын гэрээ конвенцийн тайланг хугацаанд нь илгээх, НҮБ-ын хороодоос ирсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх явдлыг сайжруулах;
- Олон улсын гэрээ, конвенцийг олон нийтэд сурталчлах;
- Олон улсын гэрээ, конвенцийн талаарх нэгдсэн мэдээллийн санг бий болгох нь зүйтэй юм.

Зургаа. ЗӨВЛӨМЖ

Олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд улс бүр дотоодын хууль тогтоомжоо түүнтэй нийцүүлэх арга хэмжээ авдаг.

Ингэхдээ олон улсын хэм хэмжээг дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хүчинтэй гэж үзэх эсвэл дотоодын хууль тогтоомжид шинээр хэм хэмжээ нэмж оруулах, хүчин төгөлдөр байгаа хэм хэмжээг өөрчлөх зэрэг аргуудыг хэрэглэдэг байна. Монгол Улсын хувьд хоёр дахь арга болох дотоодын хууль тогтоомжид шинээр хэм хэмжээг нэмж оруулан эрүү, иргэн, захиргааны гэх мэт эрх зүйн салбараар хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар дотоодын хууль тогтоомжийг олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх арга хэмжээг авдаг. Энэ тухай Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулийн 7 дугаар бүлгийн 7.27.1- т “Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Монгол Улсын хууль, хууль тогтоомжийн бусад актад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дангаар, эсхүл холбогдох яам, тусгай газартай хамтран засгийн газарт өргөн мэдүүлнэ.”, 7 дугаар бүлгийн 7.27.2-т “Монгол Улсын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай бол Засгийн газар энэ тухай санал, шийдвэрийн төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж тодорхой заасан байна.

Дотоодын хууль тогтоомжийн хүрээнд хувь хүний халдашгүй эрх болон олон улсын гэрээ, конвенцтой шууд холбогдох хуулийг сонгон авч үнэлгээ өгснийг доор хүснэгтээр харуулав.

.....

№	Конвенцийн нэр	Шинжээчдийн үнэлгээний дундаж оноо
1.	Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай пакт	3
2.	Иргэний ба улс төрийн эрхийн тухай пакт	3.7
3.	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг	3.2
4.	Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц ба Монгол Улсын хууль	4
5.	Хүүхдийн эрхийн тухай конвенц	3
6.	Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц	3.9
	МОНГОЛ УЛСЫН ДОТООДЫН ХУУЛЬ ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ГЭРЭЭ, КОНВЕНЦИД НИЙЦЭЖ БУЙ ТАЛААРХИ ШИНЖЭЭЧДИЙН ҮНЭЛГЭЭ /ХУВЬ	3.4

Монгол Улсын дотоодын хууль тогтоомж Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцид нийцэж байгаа талаарх ерөнхий үнэлгээ 3.4 оноогоор гарчээ. Энэ нь манай улсын дотоодын хууль тогтоомжийн Монгол Улсын олон улсын хүний эрхийн гэрээтэй нийцэж буй байдал “дунд зэрэг” дээш түвшинд буюу хууль тогтоомжийг шинэчлэн нийцүүлэх шаардлага байгааг илэрхийлж байна.

Гэхдээ энд Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт зэрэг зарим баримт бичгийн алгуур дэвшилтэйгээр хэрэгжих шинж чанараас үүдэлтэйгээр Монгол Улсын хувьд мөн адил өөрийн үүргээ алхам алхмаар биелүүлж байгааг анхаарвал зохино. Тийм ч учраас тус пактад нийцэж байгаа талаарх үнэлгээ хангалттай бус байхыг зөвтгөж болохыг энд дурьдах нь зүйтэй болов уу. Мөн арьс үндсээр болон хүйсээр ялгаварлан гадуурхахын эсрэг авсан үүрэг амлалтаа Монгол Улс харьцангуй сайн биелүүлж байгааг дээрх хүснэгтээс харж болно.

Гэхдээ энэхүү үнэлгээ нь Монгол Улсын дотоодын хууль тогтоомжийн Монгол Улсын олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцид нийцэж буй байдалд нь өгч буй үнэлгээ бөгөөд хэрэгжилтэд үнэлгээ өгөөгүй болно.

Иргэний ба улс төрийн эрхийн тухай пактын 14 дүгээр зүйлийн 14.6-т “Эрүүгийн хэрэг үйлдэж, шүүхийн эцсийн шийдвэрээр ял заагдсан бөгөөд шинэ буюу шинээр илэрсэн үйл баримт шүүн таслах ажиллагааны алдааг хөдөлбөргүй нотолсны учир оногдуулсан ялыг хожим хүчингүй болгосон буюу хэргийг цагаатгасан бол тэрхүү мэдэгдээгүй байсан үйл баримт тухайн үедээ илрээгүй нь бүхэлдээ буюу зарим талаар уг хүний буруугаас болсон гэдэг нь батлагдаагүй бол тийнхүү шийтгүүлсэн этгээд хуулийн дагуу хохирлоо нөхөн төлүүлнэ” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.14-т “..”бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй” гэж заасан боловч эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгаж өгөөгүй байна. Иймд шинжээчид 2.6 буюу дундаас доош үнэлгээ өгсөн бөгөөд энэ нь пактын тус заалтыг Монгол Улсын Эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгаж өгөх шаардлагатай гэж үзсэн байна.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн 2 дугаар зүйлийн 2.1-т “Дайны байдал, дайны аюул занал, дотоодын улс төрийн тогтворгүй байдал, нийтийг хамарсан онц байдал тогтоох зэрэг нь эрүүдэн шүүхийг зөвтгөх үндэслэл болохгүй”, 2.2-т “дээд шатны албан тушаалтны буюу төрийн эрх бүхий байгууллагаас авсан тушаал нь эрүүдэн шүүхийг зөвтгөх үндэслэл болохгүй” гэж заасан заалттай Монгол Улсын дотоодын хууль нийцэж байгаа байдалд шинжээчид 2 оноо өгсөн байгаа нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т “...хууль бус тушаал, захирамж өгсөн этгээдэд гэм хор учруулсны төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ”, 44.2-т “Илт хууль бус тушаал, захирамж биелүүлж энэ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ...” гэж шууд бусаар зохицуулж байгаа нь хангалтгүй гэж үзсэн байх бөгөөд улмаар Эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх хуульд пактын дээрх заалтыг бүрэн агуулгаар нь тусгах шаардлагатай юм.

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Оролцогч улсууд хүүхэд хувийн онцлог байдлаа зарим талаар буюу бүхэлд нь хууль бусаар алдахад хүрвэл даруй сэргээн тогтооход чиглэсэн тусламж, хамгаалалт үзүүлнэ”, 8.4-т “Хүүхдийн эцэг эхийн аль нэг нь буюу хоёулаа эсхүл хүүхэд нь баривчлагдах, хоригдох, цөлөгдөх, хөөн зайлуулагдах буюу нас барах (тухайн улсын хяналтад байх хугацаанд нас барах) зэргээр оролцогч улсын санаачлагаар авсан арга хэмжээний үр дүнд хүүхэд эцэг эхийн аль нэгнээс буюу хоёулангаас салах тохиолдолд аливаа шалтгаанаар хүүхдийн сайн сайхан байдалд хор учруулахааргүй бол оролцогч улсууд эцэг эх, хүүхдэд, шаардлагатай тохиолдолд гэр бүлийн бусад гишүүдэд, тэдгээрийн хүсэлтээр алга болсон гишүүний оршин байгаа газрын талаар шаардагдах мэдээлэл өгнө. Цаашид оролцогч улсууд ийнхүү хүсэлт гаргах нь зохих хүмүүст сөрөг үр дагавар бий болгохгүй байхыг хангана” гэж заасныг Монгол Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т “Засгийн газар, бүх

.....

шатны Засаг дарга, хууль тогтоомжоор эрх олгосон бусад байгууллага, албан тушаалтан эрх хэмжээнийхээ хүрээнд хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавина”, Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 7 дугаар зүйлд “Насанд хүрээгүй буюу эрх зүйн чадамжгүй хүн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлахдаа зөвхөн эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамт явна” хэмээн Монгол Улсын хуульд тусган зохицуулсан байдалд дундаас доош 2 гэсэн үнэлгээг шинжээчид өгсөн нь цаашид хуульд шууд утгаар, тодорхой тусгах шаардлагатайг харуулсан байна.

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 36 дугаар зүйлд “Оролцогч улсууд хүүхдийн аж байдлыг аливаа байдлаар хохироох аливаа бусад хэлбэрийн мөлжлөгөөс хүүхдийг хамгаална” гэсэн заалт нь Монгол Улсын аливаа хуульд тусгагдаагүй байгаа учраас шинжээчид хангалтгүй үнэлгээ өгсөн байх бөгөөд Эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах хууль, бусад хуульд холбогдох заалтыг нэн даруй тусган оруулах нь зүйтэй.

Тус конвенцийн 39 дүгээр зүйлд “Оролцогч улсууд хүүхдийг үл хайхрах, мөлжих, зүй бусаар ашиглах, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжилсон харьцаа, хандлага, зэвсэгт мөргөлдөөний хохирогч хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд нөхөн сэргээх, нийгмийн амьдралд буцаан оруулахад тус дөхөм болох шаардлагатай бүх арга хэмжээг авна. Ийнхүү нөхөн сэргээх, нийгэмд нэгтгэх үйл явц нь хүүхдийн эрүүл мэнд, нэр төр, үе тэнгийнхний хүндэтгэл хангагдсан нөхцөлд хэрэгжих ёстой” гэж заасан нь Монгол Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Хүүхдэд нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллага, аж ахуйн нэгж, иргэн дараахь үүрэг хүлээнэ:..1/хүүхдийн нас, бие бялдар, сэтгэхүйн онцлогт тохирсон, эрүүл ахуйн стандарт, шаардлага хангасан, аюулгүй, хүчирхийлэлгүй орчин бүрдүүлэх...” гэж тусгагдсаныг шинжээчид хангалтгүй гэж дүгнэсэн нь тус хуульд заасан халамж, асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хариуцна гэж заасан хэт ерөнхий зохицуулалтаар хязгаарлаад орхих бус холбогдох бусад хуульд тодорхой тусган оруулах шаардлагатай гэж үзэж байна.

ОИ.МН
СУДАЛГААНЫ САН